



Asian Development Bank

# ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА (ТАТВАР)



2023 он



# ГАРЧИГ

1.	ТАТВАРЫН ТОДОРХОЙЛОЛТ, МӨН ЧАНАР .....	5
2.	ТАТВАРЫН ХУУЛЬ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА .....	6
3.	ТАТВАРЫН ХУУЛИЙН БҮТЭЦ, ЗАГВАР .....	7
4.	ТАТВАР ХУРААХ ҮНДСЭН ЗАРЧМУУД .....	10
5.	ТАТВАРЫН АЛБА, ТҮҮНИЙ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	11
6.	ТАТВАР ТӨЛӨГЧ, ТҮҮНИЙ ЭРХ ҮҮРЭГ .....	13
7.	ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ, ТҮҮНИЙ ЗОРИЛТ .....	14
8.	<b>“АЛСЫН ХАРАА-2050” ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНУУДАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАТВАРЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ .....</b>	<b>16</b>

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад орчин үеийн татварын тогтолцоо бүрэлдэн тогтсон 30 жилийн хугацаанд орлогын, хөрөнгийн, хэрэглээний болон байгаль экологийн зэрэг бүхий л төрлийн татварын хуулиуд батлагдан мөрдөгдөж байна. Цаашид Татварын ерөнхий хуульд заасан өв залгамжлал, бэлэглэлийн татвар, нохойны албан татвар, генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр зэрэг татварын хуулиуд гарахаар хүлээгдэж байгаа бөгөөд эдийн засгийн өсөлт, тэлэлт нэмэгдэхийн хирээр татвар ногдуулах арга аргачлал улам нарийн түвэгтэй болон хөгжсөөр байна. Агаарын бохирдлын төлбөр, ус бохирдуулсны төлбөр, генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр зэрэг шинэ төлбөрүүд гарч байгааг үзэхэд цаашид ч шинэ шинэ төрлийн татвар, хураамж, төлбөр нэмэгдэх магадлалтай байна.

Монгол Улсад татвар ногдуулах, төлөх үүргийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандолоодугаар зүйлийн 17.1.3-т “Монгол улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх үндсэн үүрэгтэй” гэж тодорхойлжээ.

Улмаар татвар бий болгох, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх үүргийг бусад хууль тогтоомжоор тодорхойлжээ:

- Монгол Улсын Үндсэн хуулийн Хоринтавдугаар зүйлийн 1.7-д “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг тогтоох нь” УИХ-ын бүрэн эрхийн асуудал гэж,
- Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5.3.5, Монгол улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.3 болон 7 дугаар зүйлд “Сангийн яам, Сангийн сайд нь татварын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажил”-ыг хариуцан эрхэлнэ.
- Татварын ерөнхий хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-т Татварын алба нь:
  - 75.1.1. татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах;
  - 75.1.2. татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
  - 75.1.3. төсвийн орлогыг бүрдүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ гэжээ.

Татварыг анх судалж эхлэхэд ойлгомжгүй, сонирхолгүй байж болох ч нэг төрлийн татварыг уйгагүй судалж зүй тогтлыг нь ойлгож эзэмшсэн тохиолдолд нийт 30 төрлийн татварыг ногдуулж төлөх аргачлалыг амархан эзэмших боломжтой.

# 1. ТАТВАР БА ТҮҮНИЙ МӨН ЧАНАР

Онолын талаас авч үзвэл, улс орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэх, төрөөс зах зээлийн харилцаанд нөлөөлөх зорилгоор хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдэд төлбөрийн үүрэг хүлээлгэх санхүүгийн хэрэгслийг татвар гэнэ. Татвар нь албан татвар, төлбөр, хураамжаас тогтоно.

Татвар нь төсвийн орлогын гол эх үүсвэр болохын зэрэгцээ төрийн зүгээс улс орны эдийн засаг, зах зээлийн харилцааг тохируулах гол хэрэгслүүдийн нэг. Тухайлбал дотоодын үйлдвэрлэл, дотоод зах зээлийг дэлхийн зах зээлийн өрсөлдөөнөөс хамгаалахад гаалийн татварыг ашигладаг бол архи, тамхины үйлдвэрлэл, хэрэглээг хязгаарлах зорилгоор онцгой албан татвар ногдуулдаг.

Татвар нь нэгд, мөнгөтэй холбоотой асуудал, хоёрт, хувь хүний орлого, хэрэглээ, хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаатай шууд холбоотой байдгаас яах аргагүй хүн бүрийн сонирхох, судлах, мэдэж байх сэдэв юм. Татвар нь улс орны нийгэм, эдийн засаг, зах зээлийн харилцааны гол тохируулагч хэрэгсэл болохын хувьд улстөрчид, судлаачид, бизнес эрхлэгчдийн байнгын анхаарлын төвд байдаг сэдэв.

Татварын алба нь хуульд заасан татварыг хугацаанд нь бүрэн хураахаар ажилладаг бол татвар төлөгч хуульд зааснаас илүүг төлөхгүй байх улмаар аль болох бага татвар төлөх, эсхүл татвар төлөх хугацааг хойшлуулахыг байнга эрмэлзэж байдаг. Иймд энэ хоёр эсрэг хандлагыг нэг зүгт чиглүүлэх нь татварын албаны үйлчлэгээ, үйл ажиллагаа болон татвар төлөгчийн үүрэг хариуцлага, ёс зүйгээс шууд хамаарна. Дээрх шалтгаанаар татварын алба, татвар төлөгчдийн хооронд байнгын эрх зүйн харилцаа үүсч нэг талаас зөрчил, маргаан, хэлцэл, өрсөлдөөн, нөгөө талаас үйлчилгээ, сурталчилгааны ажил явагдаж байдаг.

Татвар нь орлого, хэрэглээ, хөрөнгөнд шууд нөлөөлж, боломжтой үедээ төлөх бололцоо олгодоггүйгээрээ хэн бүхэнд эдийн засгийн дарамт учруулж байдаг. Гэвч өнөөг хүртэл зах зээлийн харилцаанд төсвийн орлого бүрдүүлэх, зах зээлийн үйл явцад төрөөс нөлөөлж чадах, татварыг орлохуйц санхүүгийн бусад механизм гараагүй.

Татварын төсөв бүрдүүлэх үүргийг засгийн газрын зээллэг-бонд гаргах, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, төрийн болон засгийн газрын үйлчилгээг төлбөртэй болгох, төрийн өмчийг хувьчлах, гадаадаас зээл тусламж авах зэргээр түр орлуулж болох боловч эдгээр нь бүгд хязгаарлагдмал шинжтэй арга хэмжээнүүд юм.

Иймд зах зээлийн орчинд зайлшгүй оршин тогтнох - татварын хуулийн хэрэгжилтийг анхааралтай хянаж, судалж, аль болох сөрөг нөлөөлөл, дарамт багатай татвартай байлгах, түүний хэрэгжилтийг жигд, хямд зардлаар, зөв хангуулах нь татварын албаны ҮНДСЭН үүрэг юм.

## 2. ТАТВАРЫН ХУУЛЬ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгож, өөрчилж, хүчингүй болгодог. Иймд татварын хуулийн төсөл боловсруулах, хуулийг боловсронгуй болгох ажил Засгийн газар, түүний дотор Сангийн яамны чиг үүргийн хүрээнд байнга хийгдэх ажил Татварын хууль боловсруулах явцад анхаарах хэд хэдэн нийтлэг үзүүлэлт байдаг. Үүнд:



- Тэгш байдал гэдэг нь татварын хууль нь ижил үйл ажиллагаатай, ижил орлого, хөрөнгө чинээтэй хуулийн этгээд, хувь хүмүүст ижил үйлчилнэ гэсэн утгатай юм. Нөгөө талаар их орлого, их хөрөнгөтэй нь ихийг, бага орлого, бага хөрөнгөтэй бол багыг төлнө гэж тайлбарлаж болно.
- Саармаг чанар гэдэг нь татвар нь хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагааны чиглэл сонгох, хэрэглээний сонголт хийх зэргээр бизнесийн шийдвэр гаргах явцад аль болох нөлөө багатай байхыг хэлнэ. Татвар нь бизнесийн сонголт, шийдэл гаргах гол үзүүлэлт байх тусам нөлөөлөл ихтэйн шинж.
- Энгийн байх чанар гэдэг нь хуулийн утга төгөлдөр байх, үг хэллэг, агуулга, бүтэц нь зөв байх, зарчмууд нь ойлгомжтой, тодорхой байхыг хэлнэ. Уншихад ойлгогдохоор, хэрэгжүүлэхэд эргэлзээ төрүүлж, ойлгомжгүй байдал гарахааргүй байх ёстой.

Татварын хууль тогтоомж нь энгийн байснаар дагаж мөрдөхөд тохиромжтой, судалж төлөвлөхөд хямд, бүртгэл хөтлөх, тайлан гаргахад хялбар байна. Энгийн байх чанар нь татвараас зугтах, зайлсхийх боломжгүй байх нөхцлийг ч давхар бүрдүүлдэг.

- Бусад орнуудтай, ялангуяа хөрш орнуудтай бүтэц загварын хувьд ижил төстэй, ойролцоо хэмжээнд байхгүй бол хөрөнгө гадагшаа гарах, ажиллах хүчний суурьшилт тогтворгүй болох сөрөг нөлөөтэйгээс гадна хил дамнасан гүйлгээ, арилжааг татварт бүрэн хамруулахад улам түвэгтэй болно.

Эдгээр зарчмууд алдагдагдсанаар манай татварын тогтолцоонд багагүй хүндрэлүүд үүсч байсан. Жишээ нь: Татварын хувь хэмжээг 68 хувиар тогтоосноос гадна, татварыг төлж тайлагнах хугацааг хуулинд тодорхой заагаагүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байж, энэ татвар төд удалгүй хүчингүй болсон.

# 3. ТАТВАРЫН ХУУЛИЙН БҮТЭЦ, ЗАГВАР

Татварыг зөвхөн татварын хуулийн дагуу ногдуулж хураана. Иймд татварын хуулиуд ижил төстэй бүтэцтэй байдаг. Тухайлбал, Татварын хуулийн бүтцэд заавал байх дараах үндсэн элементүүд байдаг. Үүнд:

## ХЭН?

Татвар төлөгчийн тодорхойлолт, түүнийг бүртгэх, бүртгэлээс хасах зохицуулалт

## ЮУНД?

Татвар ногдох зүйлийг тодорхойлох

## ЯАЖ?

Татвар ногдуулах суурийг тодорхойлох

## ХЭД?

Татварын хувь хэмжээ

## ХЭЗЭЭ?

Ногдуулах, суутгах, төлөх, тайлагнах зарчим ба хугацаа

Дээрх үндсэн бүрдэл хэсгүүдийн томъёоллоос татварын хуулийн чанар, эдийн засгийн ач холбогдол ихээхэн хамаарна.

Татварын хуульд байх гол хэсэг нь татвар төлөгчийг тодорхойлох явдал. Татвар төлөгч нь хувь хүн, хуулийн этгээдүүд, аж ахуйн нэгжүүд, гадаадын аж ахуйн нэгж, төлөөний газрууд байж болно. Энэ хэсэгт бүртгэх, бүртгэлээс хасах үйл ажиллагаа хамаарна.

Татварын ногдох зүйл нь тухайн хуулиар юунд татвар ногдуулахыг тодорхойлно. Орлого, хэрэглээ, эсхүл тодорхой төрлийн бараа, ажил, үйлчилгээ, хөрөнгө, байгалийн баялаг олборлосон, ашигласан, хэрэглээнд ногдуулж болно. Иймд энэ хэсэг нь татвар ногдох объектыг нарийн тодорхойлох хэсэг юм.

Татвар ногдуулах зүйлийн шинж чанараас хамаарч татвар ногдуулах (суурь) аргачлалыг зааж өгөх ёстой. Тухайлбал, Галт зэвсгийн албан татварыг бууны калибрийн хэмжээ, автомашин буюу тээврийн хэрэгсэлд хөдөлгүүрийн багтаамж, даацын хэмжээнд үндэслэдэг бол аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг орлого зардлын зөрүүгээр гэх мэтээр татвар ногдох суурийг тодорхойлж өгдөг.

Татварын хувь хэмжээ бол татварын хуулинд байх гол бүрдэл хэсэг юм. Татварын хувь хэмжээг тогтмол дүнгээр, хувь процентоор, өсөн нэмэгдэх хэлбэрээр шатлалтай, мөн үрвүү шатлалтай байдлаар тогтоож болно.

Татварын хууль тогтоомжид хугацааны асуудал чухал байр суурь эзэлдэг. Татварын хуулинд татвар ногдуулах эсхүл суутгах, төсөвт төлөх, тайлагнах хугацааг заавал тодорхойлж өгдөг.

Ийнхүү татварын хуулиуд нь дээрх бүрдэл хэсгүүдийг агуулсан байх бөгөөд хэрэв аль нэг хэсэг нь тодорхойгүй л бол тухайн хуулийн хэрэгжилт үр дүнгүй болох талтай. Жишээ нь: Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татварын хувьд татвар ногдуулах суурийг тодорхойлох, төсөвт төлөх тайлагнах хугацааг тодорхойлох хэсгийг дутуу боловсруулсны улмаас бүрэн хэрэгжүүлэх боломжгүйд хүрч Монгол улсын Үндсэн хуулийн цэц дээр хэлэлцэгдэж, хуульд удаа дараа өөрчлөлт орж байсны эцэст хүчингүй болгож байжээ.

Татварын хөнгөлөлт чөлөөлөлт, хариуцлагын тогтолцоог татварын хуулийн үндсэн бүтцэд оруулдаггүй бөгөөд зөвхөн нэн шаардлагатай тохиолдолд оруулдаг. Иймд аливаа татварын хуулийг өөрчлөхөд дээрх иж бүрдлийг салгаж хэлэлцэж болдоггүй. Татварууд хоорондоо харилцан уялдаатай тул тогтолцоогоор нь, цогцоор нь авч үзэж шинжилнэ.

Татварын ерөнхий хуульд зааснаар Монгол улс нийт 30 төрлийн татвартай байхаар тусгагдсанаас Өв залгамжлал бэлэглэлийн албан татвар, Нохойны албан татварын хууль, Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөрийн тухай хууль хараахан батлагдаагүй, хэрэгжиж эхлээгүй байна.

	Татварын нэр	Татвар төлөгч	
ТАТВАР	1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа компани, нөхөрлөл болон бусад аж ахуйн нэгж, байгууллага
	2	Гаалийн албан татвар	Хилээр бараа импортолж, экспортолж байгаа этгээд
	3	Нэмэгдсэн өртгийн албан татвар	Бараа ажил үйлчилгээ борлуулагч, худалдан авагч
	4	Онцгой албан татвар	Согтууруулах ундаа, тамхи, автобензин, дизелийн түлш, автомашин үйлдвэрлэгч, импортлогч, мөрийтэй тоглоомын тоног төхөөрөмж эзэмшигч/ашиглагч
	5	Автобензин, дизелийн түлшний албан татвар	Автобензин, дизелийн түлш үйлдвэрлэгч, импортлогч
	6	Хувь хүний орлогын албан татвар	Орлого олж байгаа хувь хүн
	7	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	Үл хөдлөх хөрөнгө өмчлөгч хувь хүн, хуулийн этгээд
	8	Малын тоо толгойн албан татвар	Мал бүхий этгээд, малчин
	9	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	Монгол улсад автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч
	10	Галт зэвсгийн албан татвар	Буу, галт зэвсэг эзэмшиж буй этгээд
	11	Нийслэл хотын албан татвар	Согтууруулах ундаа, тамхи худалдан авагч, баар, зочид буудал, амралтын газар, зочид буудлын үйлчилгээ авсан этгээд



ТАТВАР	12	Нохойны албан татвар	(хууль гараагүй)
	13	Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар	(хууль гараагүй)
ТӨЛБӨР	14	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Ашигт малтмал олборлогч, ашиглагч, дамжуулан борлуулагч
	15	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч
	16	Агаарын бохирдлын төлбөр	Нүүрс олборлогч, агаар бохирдуулах эх үүсвэр эзэмшигч
	17	Ус бохирдуулсны төлбөр	Ус ашиглан хаягдал гаргаж, бохирдуулсан этгээд
	18	Газрын тосны нөөц ашигласны төлбөр	Газрын тос олборлогч
	19	Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Газрын тос хайх, олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч
	20	Газрын төлбөр	Хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, ашиглах эрхтэй этгээд
	21	Байгалийн ургамал ашигласны төлбөр	Байгалиас ургамал түүсэн этгээд
	22	Усны нөөц ашигласны төлбөр	Байгалийн ус ашигласан этгээд
	23	Рашаан ашигласны төлбөр	Рашаан ашиглаж буй этгээд
	24	Ойн нөөц ашигласны төлбөр	Ойн нөөц, ойгоос мод, түлээ ашиглаж буй этгээд
	25	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	Ан амьтан барьсан, агнасан этгээд
	26	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Элс, хайрга, дайрга зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон этгээд
	27	Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр	Генетик нөөцтэй холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигч нь
	ХУРААМЖ	28	Улсын тэмдэгтийн хураамж
29		Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглах зөвшөөрлийн хураамж	Байгалийн баялаг ашиглах зөвшөөрөл хүссэн этгээд
30		Хог хаягдлын үйлчилгээний хураамж	Хог хаягдал гаргаж буй этгээд

## 4. ТАТВАР ХУРААХ ҮНДСЭН ЗАРЧМУУД

Татварын тогтолцоог татвар ногдуулж, хураах талаас нь:

Татвараа өөрөө  
ногдуулж төлөх зарчим

Татварын алба нь  
татварыг нь ногдуулж  
хураах зарчим

Монгол улсын татварын тогтолцоо нь self-assessment system буюу татвар төлөгч нь татвараа өөрөө ногдуулж төлөх зарчимтай. Энэ зарчмаар татвар төлөгч нь татвараа өөрсдөө тооцоолон гаргаж төсөвт төлж тайлагнах үүрэг хүлээж, татварын алба нь татвар төлөгчдөө мэдээллээр хангаж, арга зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлж, татвараа үнэн зөв тодорхойлж, хуульд заасан хугацаанд төлөх боломж, дэд бүтэц, шаардлагатай нөхцлийг хангах үүрэгтэй.

Татвараа буруу болон дутуу ногдуулсан тохиолдолд татвар төлөгч нь хариуцлага хүлээдэг. Энэхүү зарчим нь татвар хураах зардлыг ихээхэн хэмнэх боловч татварын албыг үйлчилгээ, сурталчилгаа, сургалт, судалгааны байгууллага байхыг шаарддаг.

Татварын албанаас төлөх татварыг нь тодорхойлж хураах зарчим буюу official-assessment system нь сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад нэлээд түгээмэл болжээ. Ялангуяа мэдээллийн технологи хөгжихийн хирээр төлөх татварыг нь татварын алба нь тодорхойлох зарчим нэн хурдацтай хөгжиж байна.

Монгол улсын хувьд ч татварын алба нь цахим төлбөрийн баримт, гаалийн мэдээлэлд үндэслэн НӨАТ суутган төлөгчийн тухайн сарын НӨАТ-ын ногдлыг тодорхойлох боломжтой болгожээ. Цаашид ч мэдээллийн нэгдсэн системд үндэслэн татвар төлөгчийн төлбөл зохих татварыг нь тодорхойлж татвар төлөгчдөд мэдээлэх, хэрэв зөвшөөрвөл төлж барагдуулах, зөвшөөрөхгүй бол хариу мэдэгдэж 2 талаас хяналт хийж шинэчлэн тодорхойлох зарчим руу шилжиж байна.

Өнөөгийн байдлаар хөрөнгийн татварууд: газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар, галт зэвсгийн албан татвар, тээврийн хэрэгслийн албан татвар, малын тоо толгойн албан татвар, байгалийн нөөц ашигласны төлбөрүүд болон агаар, усны бохирдлын төлбөрийн ногдлыг татварын алба нь тодорхойлох боломж бүрдсэн байна.

Татварын албаны цахим систем [www.etax.mta.mn](http://www.etax.mta.mn), [www.itax.mta.mn](http://www.itax.mta.mn)-ээр дамжуулан татвар төлөгчөөр бүртгүүлэх, татварын тайланг гаргах, илгээх, засварлах, цахим төлбөрийн баримт үүсгэх, татвар төлөх дэд бүтэц бий болжээ.

Дээрх хувилбаруудаас гадна дундын суутгалын аргыг татварын албанд өргөн хэрэглэдэг. Энэ нь татварыг хямд зардлаар, эх үүсвэрээс нь гаргуулж авах арга юм. Дундын суутгалын аргыг Монгол улс өргөн ашигладаг ба татварын цахим системийн тусламжтайгаар энэ аргачлалын үүрэг, ач холбогдол улам боловсронгуй болж байна.

## 5. ТАТВАРЫН АЛБА, ТҮҮНИЙ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Татварын албадын бүтэц зохион байгуулалтыг зарчмын хувьд дараах үндсэн 3 бүлэгт хуваадаг.

Татварын төрлөөр  
/орлогын, хөрөнгийн  
татварын, төлбөр  
хураамжийн гэх мэт/

Үйл ажиллагааны  
чиглэлээр  
/татвар төлөгчийн  
бүртгэл, үйлчилгээ  
сурталчилгаа, татвар  
хураалт, хяналт шалгалт,  
эрсдэл, мэдээллийн  
технологийн хэлтэс  
гэх мэт/

Татвар төлөгчдийн  
ангиллаар  
/том, дунд, жижиг,  
бичил, хувь хүн, гадаад,  
дотоодын хөрөнгө  
оруулалттай гэх мэт/

Монголын татварын алба үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдсан ангилалд багтах боловч холимог тогтолцоотой юм. Учир нь Татварын Ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар хэлтсүүдийн бүтцийн нэгжүүд нь үйл ажиллагааны чиглэлээр буюу татвар төлөгчдөд үйлчлэх, татварын орлого хураах, хяналт шалгалт гэх зэргээр зохион байгуулагдсан. Гэвч татварын харьяаллыг нь том татвар төлөгчид, дунд татвар төлөгчид, жижиг, бичил, хувь хүн татвар төлөгч гэж ангилан харьяалуулж байгаагаас үзэхэд холимог бүтэцтэй гэж тодорхойлж болно.

Татварын албаны үйл ажиллагааны үр дүнг татвар хураалтын зардал гэдэг үзүүлэлтээр хэмжих ба татварын албаны төсөв ба нийт хураасан татварын орлогын харьцаа юм. Энэ дүн 2021 оны байдлаар 0.22 мөнгө буюу 1 төгрөгийн татвар хураахад 0.2 мөнгө зарцуулж байна. Энэ нь ойролцоогоор татварын алба 1 төгрөг зарцуулж 500 төгрөгийн татвар хураадаг гэсэн агуулгатай юм.



Түүнчлэн татварын албаны үйл ажиллагааны түвшинг үнэлэх чанарын олон үзүүлэлт байдаг.

1

Татварын байцаагч нарын ур чадвар (боловсрол мэргэшлийн түвшин, татвар төлөгчид зөвлөлгөө өгөх, татварын зөрчил илрүүлэх чадвар)

2

Институцийн хувьд (төсөв, тоног төхөөрөмж, ажлын байрны хангамж, мэдээлэл гаргуулах эрх, хөрөнгөд халдах эрх, хууль тайлбарлах эрх )

3

Үйлчилгээний түвшин (үйлчилгээнд зориулсан хүний болон санхүүгийн нөөц, мэдээллийн технологи, мэдээлийн бааз ашиглалтын түвшин)

4

Татварын албаны нэр хүнд (ялангуяа ажилтан албан хаагчид нийгэмд нэр хүндтэй байх)

Татварын алба нь татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихын тулд төрийн болон орон нутгийн төр, захиргааны байгууллагууд болон Татварын ерөнхий хуульд заасан бусад байгууллагуудтай байнгын харилцаатай ажиллах үүрэгтэй. Энэ нь нэг талаас татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа асуудал ба нөгөө талаас татвар төлөгчдөө мэдээллээр хангаж, аливаа эрсдэлд орохоос урьдчилан сэргийлж байгаа ажиллагаа юм.

Татварын албаны хамгийн гол үзүүлэлт бол татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийн тулд олон нийтэд татварын хуулийг сурталчлан таниулах, мэдээ мэдээллээр хангах, төсвийн орлогын биелэлтийг хангах явдал юм.

## 6. ТАТВАР ТӨЛӨГЧ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандолдугаар зүйлд “хуулиар ногдуулсан албан татвар төлөх нь” иргэн бүрийн ёсчлон биелүүлэх үндсэн үүрэг гэж тодорхойлсон. Иймд хувь хүн, хуулийн этгээд, оршин суугч бус гадаадын иргэд, харьяалалгүй хүн, Монгол улсад байрладаггүй ч хуулийн дагуу татвар төлөх үүрэг бүхий гадаадын аж ахуйн нэгж, тэдгээрийн төлөөний газар Монгол улсад Татвар төлөгч байна. Татварын хууль бүрд татвар төлөгчийг тодорхойлсон байдаг бөгөөд татвар төлөгчөөр бүртгүүлэх, түүний эрх үүргийг Татварын ерөнхий хууль болон бусад татварын хуулиудад нэг бүрчлэн зааж өгдөг.

Татвар төлөгч нь хуулийн дагуу татвар төлөх үүрэгтэй ч аль болох бага татвар төлөхийг эрмэлздэг ба татвар төлсний хувьд төрөөс аль болох их дэмжлэг, үйлчилгээ авахыг эрмэлзэж байдаг.

Иймд татварын албаны зүгээс татвар төлөгчийн эрх үүрэг, тэдний хүлээх хариуцлагыг байнга таниулж, тайлбарлаж ухамсарлуулж байх үүрэгтэй.

Бусад орнуудтай харьцуулахад Монгол улсын татвар төлөгчдийн эрх хангалттай өргөн гэж тооцогдоно. Түүнчлэн татварын алба нь татвар төлөгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, тэдэнд итгэл үзүүлэн ажиллах үүрэг хүлээсэн байдаг. Үүргийн хувьд бусад орны нийтлэг жишигт нийцэж байна. Харин татварын хууль тогтоомж зөрчигсдөд ногдуулах хариуцлагын тогтолцооны хувьд нэлээд хатуу хариуцлага хүлээлгэдэг.

Нэг татвар төлөгч нь маш олон төрлийн татвар төлөх үүрэг хүлээдгээс татвар төлөгчийн дугаарыг (хувь хүн, хуулийн этгээдийн бүртгэлийн болон регистрийн дугаар) ашигладаг бөгөөд энэ дугаарын ашиглалтыг улс орон даяар өргөсгөх нь татварын албанд ихээхэн ач холбогдолтой.

Татвар төлөгчийг бүртгэх үйл ажиллагаа нь татварын албаны үйл ажиллагааны хамгийн анхны үе шат бөгөөд хамгийн хариуцлагатай үйл ажиллагаа юм. Энэ үеэс эхлэн татвар төлөгчийг мэдээллээр хангах, тэдэнд үйлчилгээ үзүүлэх ажил эхлэх тул эхнээс нь сайн харилцаа үүсгэхийг чухалчилдаг.

Татварын нэр төрөл олшрох тусам татварын хуулийг нэг бүрчлэн хэрэгжүүлэх, татварын тайлан гаргах, татвар төлөх, баримт материал хөтлөх гээд багагүй зардал гарна. Үүнийг татвар ногдуулах зардал гэх бөгөөд татварын алба нь аль болох татвар ногдуулалтын зардлыг бууруулах чиглэлд хөрөнгө оруулалт хийж, сурталчилгаа үйлчилгээг ч энэ чиглэлд хандуулдаг. Мэдээллийн цахим систем энд голлох үүрэгтэй байна.

## 7. ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ ТҮҮНИЙ ЗОРИЛТ



Татварын шинэчлэл гэдэг нь хэзээ ч үл төгсөх процесс юм. Зах зээл, нийгэм эдийн засгийн бодлого, чиг хандлага хөгжиж өөрчлөгдөхийн хирээр татварын орчин хувьсан өөрчлөгдөх болно.

Татварын шинэчлэл гэдэг нь зөвхөн шинэ татвар нэвтрүүлэхийн нэр биш, хувь хэмжээг нь өөрчлөхийн ч нэр биш. Харин зах зээл, нийгэм, эдийн засгийн орчин, чиг хандлагад тохируулах үүднээс татварын бодлого, тогтолцоонд цогц өөрчлөлт оруулахыг хэлнэ.

Хамгийн гол нь татварын шинэчлэл нь тэгш шударга, энгийн, татвар төлөгчдөд илүү боломж олгосон, бизнесийн орчныг улам таатай болгосон чиглэлд өөрчлөгдөх ёстой.

Монгол улс 2006, 2019 онуудад татварын томоохон шинэчлэл хийсэн. Энэ нь татварын дарамтыг бууруулах, хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгаж, чөлөөтэй тэгш шударга өрсөлдөөн бий болгох, гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлдэг байсан давуу нөхцлийг зогсоох зэргээр эдийн засгийн шилжилтийн нөхцөлд чиглэсэн хандлагыг өөрчилж, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн томоохон шинэчлэл болсон.

Татварын шинэчлэл нь өмнөх бодлого зорилтот үүргээ биелүүлсэн, цаашид илүү үр дүн гарч болох шинэ нөхцөл байдал үүссэн үед төлөвлөгдөж хэрэгждэг. Гэвч энд татварын шинэчлэлээс илүүтэйгээр татварын эрхзүйн орчны тогтвортой байдал, татвар ногдуулалт, татвар хураалтын зардлыг бууруулах үндсэн нөхцөл байнга хамт яригдах ёстой.

Цаашид Монгол улсын татварын тогтоолцоонд өөрчлөлт шинэчлэл хийх олон санал санаачилгууд гарах ба эдгээр нь нийгмийн хамгаалал, хөрөнгө оруулалт, үйлдвэржүүлэлтийн бодлого гээд төрийн бүхий л бодлого хөтөлбөртэй нягт үялдах ёстой.

Татварын шинэчлэл хийхэд гадаад дотоод нөхцөл бүрдсэн байх шаардлагатай бөгөөд гадаад нөхцөлд дэлхийн зах зээлийн чиг хандлага, бүс нутгийн болон хөрш орнуудын байдал мөн улс орны эдийн засгийн төлөв байдал хамаарна. Эдгээр нөхцөл байдал нь татварын хууль тогтоомжийг өөрчлөх шаардлагатай байгааг нотолж байх ёстой.

Дотоод нөхцөл байдал гэж татварын хууль тогтоомж нь татвар төлөгчдийн үйл ажиллагаанд тохирохгүй байгаагаас хууль тогтоомжийн хэрэгжилт буурахыг хэлнэ.

Монгол улсын эдийн засгийн бүтэц өөрчлөгдөж, уул уурхай, эрдсийн түүхий эдийн экспортын өсөлттэй холбоотойгоор төсвийн орлогын хэмжээ эрс нэмэгдэж улмаар төсвийн хөрөнгө оруулалт, нийгмийн халамжийн хэмжээ ч жил бүр нэмэгдсэн.

Үндсэн татваруудын хувь хэмжээ хамгийн доод боломжит түвшинд хүрсэн байдаг. Зах зээлийн шаардлагаар хэзээ нэгэн цагт өсгөх шаардлага гарах тул хувь хэмжээг бууруулахын оронд хөнгөлөлт чөлөөлөлтийг нэмэгдүүлэх, хасагдах зардлыг нь нэмэгдүүлэх, татвар төлөх давтамжийг цөөлөх гээд татварын хуулийн бусад иж бүрдлийг тохируулга хэлбэрээр ашиглах ёстой. Татварын хувь хэмжээг өөрчлөх нь хамгийн эмзэг бөгөөд мэдрэмтгий өөрчлөлт юм.

Манай улс дэлхийн нийтлэг хандлага болох татварын алба нь хувь хүн хуулийн этгээдийн татварын ногдлыг нь аль болох алдаагүй тодорхойлж татвар төлөгчдөд хүргүүлэх, татвар төлөгч нь түүнийг хянаж эргэж тайлагнах гэдэг зарчим руу амжилттай шилжиж байна.



# 8. “АЛСЫН ХАРАА-2050” ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАТВАРЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ

Татварын тогтолцоо, түүний чиг үүргийн талаар мэдлэгтэй болсон та бүхэн ирэх 10 жилийн хугацаанд Монгол улсын татварын тогтолцоонд орохоор хүлээгдэж буй дараах татварын бодлого чиглэлтэй танилцан өөрсдийн үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжүүлэх арга замын талаар эргэцүүлэн бодоорой. Үүнд:



Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах, архи, тамхи, эм, чихэрлэг ундааны онцгой албан татварын тодорхой хувийг эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ.



Илчлэг, транс тос, чихэр, давсны агууламж өндөр хүнс, чихэрлэг ундааны үйлдвэрлэл, худалдааг татварын бодлогоор хязгаарлах, хүнсний аюулгүй байдлын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.



Тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүний импортын татвар, зохицуулалтыг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан хүрээнд үр ашигтай хэрэгжүүлнэ.



Хотын татварыг төрөлжүүлэн онцгой татвар бий болгоно.



Төрөөс хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтыг бодлого, татварын орчноор дэмжинэ.



Сайжруулсан түлш, цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлж, нэмэгдсэн ертгийн албан татвараас чөлөөлнө.





Улаанбаатар хотын ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, хотыг цэцэрлэгжүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг бий болгоно.




Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг гааль, татвар, зээлийн бодлогоор дэмжинэ.




Төрийн бодлого, татварын хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулалтыг хамгаалах, татах таатай орчныг бүрдүүлнэ.



Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай шинжлэх ухааны парк, инновацийн татваргүй бүсийг хамтын оффист түшиглэн байгуулна.



Орон сууцны төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд татварын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар тухайн орон сууцны тодорхой хувийг бага, дунд орлоготой иргэдэд түрээслүүлэх, хямд үнээр борлуулах замаар орлогод нийцсэн орон сууцаар хангана.



Хиймэл оюун ухаан болон блокчейн технологид суурилсан газрын үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг бий болгоно.



Татварын шинэ хуулийг хэрэгжүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ.



